

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлэх зэрэг гүйцэтгэх гэрээний биелэлт

Эрээний дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 оны төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Аймгийн Засаг дарга, Тамгын газар болон бусад байгууллагын зүгээс хэрэгжүүлэхэд оролцсон тайлан	Хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан, үндэслэл, тайлбар	Хэрэгжилтийн хувь	Дундаж хувь
Эр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.												
1.	Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах	-	Угийн бичгийн хөтлөлтийн хувь	2018 оны судалгаагаараа гарсан улсын дундаж үзүүлэлт	Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна.	100	1,500,000	Улсын төсөв	"Нэг өрх-Нэг угийн бичиг 2" аяныг 2025 оны 02-04 дүгээр сард зохион байгуулж, бүх сум, байгууллага нэгдэж идэвхтэй оролцлоо. Угийн бичиг хөтлөх арга зүйгээр сургагдсан 3 сургагч багшаар дамжуулж, албан хаагчид, иргэд, ахлах ангийн хүүхдүүдийн дунд "Угийн бичгээ хөтлөж хэвшье" сургалтыг зохион байгуулж, 12 байгууллагын 200 гаруй албан хаагч, 8 сургуулийн 324 хүүхэд хамрагдаж, мэдээлэл авлаа. Аяны хаалтын арга хэмжээнд сумдаас угийн бичиг тогтмол хөтөлдөг 35 оролцогч оролцож, үзэсгэлэнд өөрсдийн бүтээлийг үзүүлж, туршлагаа хуваалцлаа. Угийн бичиг хөтлөх, E-family сайтыг ашиглах заавар зөвлөмжийг иргэдэд хүргэх чиглэлээр Арвайхээр сумын 13 багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудад арга зүйн сургалт, мэдээлэл өгч чадавхижууллаа. 2025 онд аймгийн хэмжээнд угийн бичиг		Хэрэгжсэн	
3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:												
2.1.	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх		1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь	2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо	Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	1 88,7 хувь	3,500,000	Улсын төсөв	Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй, цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, гэр бүлийн эрүүл, тогтвортой харилцааг бэхжүүлэхээр "Халуун ам бүл 1" төслийг 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 07/02 тогтоолоор батлуулж, төлөвлөгөөний дагуу бүх сум, байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг 67 удаа зохион байгуулж, арга хэмжээнд 4,752 хүүхэд, 3,115 эцэг эх асран хамгаалагч, 92 аж ахуйн нэгж, байгууллага оролцсон байна. "Аз жаргалтай гэр бүл" вакум сургалтыг 5 суманд 6 удаа зохион байгуулж, 64 хос буюу 128 хүн, "Халуун ам бүл-1" төслийн хүрээнд гэр бүлийн боловсрол олгох сургалт, хэлэлцүүлгийг 2 үе шаттай зохион байгуулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 18 хэлтэс, агентлагийн удирдлага, СӨББ-ын эрхлэгч, арга зүйч 11 хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн 91 албан хаагч, Арвайхээр сумын харъяат 65 гэр бүлийн 140 гаруй иргэн хамрагдаж мэдээлэл авсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 бүртгэгдэж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2 нэгжээр буюу 25.0 хувиар өссөн бол иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэл шинжтэй 133 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 нэгжээр буюу 24.4 хувиар буурсан байна.		Хэрэгжсэн	

2.2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	22,500.0	1. Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь	2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.	121	14,500,000	Улсын төсвөө	<p>Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдрийг угтан "Хариуцлагатай эцэг, эх байя" сургалт зохион байгуулж, 87 иргэн, олон улсын гэр бүлийн өдрийн хүрээнд 4 төрлийн нэгдсэн арга хэмжээнд 1300 гаруй иргэн, гэр бүл оролцож, амралтын өдрийг гэр бүлдээ чанартай цаг гаргаж, хамтдаа хөгжиж, үр дүнтэй өнгөрүүлээ. Мөн "Эрүүл нийгмийг бүтээхүйд эрчүүдийн оролцоо" нөлөөллийн ажлыг 11 суманд зохион байгуулж, 938 эрэгтэйчүүд, залуучууд оролцлоо. "Халуун ам бүлд, хайрлагдсан хүүхдүүд" хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг Арвайхээр сумын багууд дээр зохион байгуулж, тусгай хэрэгцээт 11 дүгээр цэцэрлэгийн байнгын асаргаа шаардлагатай 32 хүүхэд, 25 эцэг эхэд "Арт терапи" буюу урлагийн сэтгэл зүйн засал, зургаар дамжуулж өөрийгөө илэрхийлэх, сэтгэл зүйгээ өөрчлөх сургалтыг зохион байгуулж, хүүхэд хамгааллын анхан шатны 32 багц хэрэглэгдэхүүнийг өгч, эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна. Хорих ял эдлээд суллагдсан 15 иргэнийг нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж, "Засрал, хүмүүжил, төлөвшил" аяныг зохион байгуулж, 3 удаагийн сургалт, гэр бүлийн гишүүдийг хамруулсан сэтгэл зүйн зөвлөгөө, уулзалтыг зохион байгууллаа.</p> <p>Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяанд хүмүүжиж буй 7 иргэнийг 14 хоногт 1 удаа ганцаарчилсан болон нэгдсэн сургалтад давтамжтай хамруулж, сургалтын үр дүнд 2 хүмүүжигч хугацаанаас өмнө шүүхийн магадлангаар суллагдсан байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтыг Арвайхээр суманд зохион байгуулж, гэр бүлдээ хүчирхийлэл үйлдсэн 26 иргэнийг хамруулж, зөвлөгөө мэдээлэл өглөө. Эрүүлжүүлэх, саатуулах байранд саатуулагдсан иргэдэд 6 удаагийн сургалт зохион байгуулж, 100 гаруй иргэн хамрагдсан байна.</p>	хэрэгжсэн
3.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	-	Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна.	0	0	<p>Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төв, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчид хандаж, 700 гаруй хүүхэд, 89 иргэн, нийт 800 орчим иргэн үйлчлүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Аймгийн хэмжээнд 7 төрийн байгууллагын дэргэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө ажиллаж, зөвлөгөө мэдээлэл өгөх Opesall үйлчилгээг шинээр нэвтрүүлж эхлээд байна. 2025-2026 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагат 1, ерөнхий боловсролын сургуулиудад 17 сэтгэл зүйч ажиллаж, хүүхэд, багш, ажилтан, эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж байна. "Халуун ам бүлд, хайрлагдсан хүүхдүүд" хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд Арвайхээр сумын тусгай хэрэгцээт 11 дүгээр цэцэрлэгийн байнгын асаргаа шаардлагатай 34 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч 26 иргэнд "Арт терапи" буюу урлагийн сэтгэл зүйн засал, зургаар дамжуулж өөрийгөө илэрхийлэх, сэтгэл зүйгээ өөрчлөх сургалтыг зохион байгуулж, 18 эцэг эх, асран хамгаалагчид сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна. Төгрөг, Нарийнтээл, Гучин-Ус, Сант суманд "Сэтгэл зүйчдийн баг" явуулын үйлчилгээ ажиллаж, ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн 899 сурагчид ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан. Хүүхдийг амьдрах ухааны үр чадварт сургах, мэргэжил сонголтод туслах чиглэлээр ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, насан туршийн суралцахуйн төвийн арга зүйч багш нар нийт 70 албан хаагчийг хамруулсан 3 өдрийн сургалт зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 7,8 сая төгрөг зарцуулсан. Сургалтаар эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжил сонголтын чиглэлээр зөвлөгөө өгч, багш, менежерүүдэд сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүй, суралцагчийн нас, сэтгэлзүйн онцлог, судалгаа оношилгоонд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүйг олгож, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үр</p>	Хэрэгжсэн	

1.2.4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	2024 онд баталсан төсөв	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна.	11.5	Орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг Түр хамгаалах байрын цэвэр бохирын шугам сүлжээний засварын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тусгаж, зураг төсөл, төсвийн тооцоо хийгдсэн боловч улс, орон нутгийн төсөв, санхүүгийн хүндэрлээс шалтгаалан 2026 онд хийхээр төлөвлөлтөд ороод байна. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/52 дугаар захирамжаар Түр хамгаалах байранд ажиллах 2 нийгмийн ажилтны орон тоог баталж, 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн томилогдон ажиллаж байна. Түр хамгаалах байранд ажиллаж буй нийгмийн ажилтнуудын цалин, байрын урсгал	Хэрэгжсэн
НИЙТ									

3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:

3.1.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;		1.Төлөвлөгөө баталсан эсэх 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	1 60 хувь	1,000,000	Улсын төсөв	Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллыг сайжруулж, хүүхэд эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахаар 4 жилийн хугацаанд хэрэгжих "Хайрлагдсан хүүхэд" бодлогын баримт бичгийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2025 оны 07/01 дүгээр тогтоолоор батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг бүх сум, байгууллагуудад албан бичгээр хүргүүлээд байна. "Хайрлагдсан хүүхэд" төслийг хэрэгжүүлэх уулзалт хэлэлцүүлгийг сум, аж ахуй нэгж, байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөл, байгууллагуудын хүрээнд зохион байгуулж, тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүх шатанд хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулж, хүүхэд ээлтэй, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төр, төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хамтран хэрэгжүүлэхээр санал нэгдлээ. Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар салбар зөвлөлийн дүрэм, хүүхдээ сонсох өдрийн товыг тогтоож, тогтоолоор баталснаар 6 суманд хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулж, тусгай хэрэгцээт хүүхдүүдийг тээвэрлэх автобустай болох, хүүхдүүдийн уралдаан тэмцээнд оролцох зардлыг шийдвэрлэх, тоглоомын талбайн эвдрэл гэмтлийг засварлах, эрсдэлийг бууруулах зэрэг асуудлыг үе шаттай шийдвэрлэж байна.	Хэрэгжсэн
3.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;		Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	2024 онд хамрагдсан хүүхдийн тоо	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.	100 хувь	52,500,000	Улсын төсөв	Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих 25 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 15 мянга гаруй хүүхэд хамрагдсан байна. Үүнд: хүүхдийн чуулган, Байгальд ээлтэй залуусын чуулган, Теен парламент, мэргэжил сонголт, амьдрах ухааны сургалт, хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээ, хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын тоглолт, Театр-27, "Үндэсний илтгэлийн тэмцээн", "Зөв нийгмийг цогцлоохын төлөө, зөв мэдээллийг түгээе" сэдэвт илтгэлийн уралдаан зэрэг 25 төрлийн үйл ажиллагаанд 15 мянга гаруй хүүхэд хамрагдаж, оролцсон байна. Англи хэлний дугуйлангийн сурагчид "Ромео & Жульетта" жүжгийг орон нутагт анх удаа англи хэл дээр тоглож, хүүхэд залуучуудын хүртээл болгож, талархал хүлээлээ. Хүүхдийн урлаг, спортын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, аймаг, бус, улс, олон улсын уралдаан тэмцээнд оролцох ур чадвар эзэмшүүлэх секц, дугуйлан, сургалтын төв урлагийн чиглэлээр 18, спортын чиглэлээр 26, танин мэдэхүй, мэдлэг олгох, бататгах чиглэлээр 14 хичээллэж, 8000 гаруй хүүхэд хамрагдаж байна.	хэрэгжсэн
3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;	1,684,863.6	Баталсан төсвийн хэмжээ	2024 онд баталсан төсөв	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.				Аймгийн Засаг даргын 2023 оны А/173 дугаар захирамжаар Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн зөвлөл бүх сумдад байгуулагдаж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үндэсний хэмжээнд бэлтгэгдсэн сургагч багштай гэрээ байгуулж, 11 сумын 920 иргэн, эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулаад байна.	хэрэгжсэн

1.3.4.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	-	-	"Аюулгүй орчин-Аз жаргалтай хүүхэд" 30 хоногийн аян өрнүүлж хүүхдийг осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэхэд нийтийн эзэмшлийн гудамж талбай, тоглоомын талбай, сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлт байдлыг илрүүлэх, арилгах, бууруулах ажлыг Арвайхээр сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудын оролцоотойгоор зохион байгуулж, 59 тоглоомын талбайд эрсдэлийн үнэлгээ хийснээс 49 тоглоомын талбай эрсдэлтэй байна. Гэр хорооллын 8 тоглоомын талбайгаас 8, орон сууцны гаднах 30 тоглоомын талбайгаас 27, сургууль, цэцэрлэгийн 21 тоглоомын талбайн 14 нь эрсдэлтэй байсныг илрүүлж, зөрчлийг арилгууллаа. Хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны эхний хурлаар Хүүхэд хөгжлийн зуслан байгуулах газрын асуудлыг хэлэлцүүлж, стандарт шаардлагат тохирох 10 га газрыг Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр багийн нутаг "Пэрлэй нүүрийн нам модны ар" гэдэг газар байгуулахаар сонгож, орон нутгаас газрын асуудлыг шийдвэрлэсэн. 2025 онд зураг, төсвийг хийлгэхээр зургийн даалгавар гарч, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон	-	хэрэгжээгүй
1.3.5.	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах;	Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	-	Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна.	2,000,000	Улсын төсвө	Аймгийн хүүхдийн зөвлөлийн сурагчид үндэсний хэмжээний хүүхдийн зөвлөлийн зөвлөгөөн, "Өсвөрийн парламент" зэрэг арга хэмжээнд оролцож, танхимын сургалт үйл ажиллагаанд 600 гаруй, цахим арга хэмжээнд 1000 гаруй хүүхэд хамрагдаж, хүүхэд хүүхэддээ эерэгээр нөлөөлөх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог ханган ажиллаж байна. Хүүхдийн оролцооны байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, аймгийн Хүүхдийн ордонд өрөө тохижуулан, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өгснөөр хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаа тогтмолжиж байна.	-	хэрэгжээгүй
1.3.6.	"Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.	1.Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо	-	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна.	-	-	Аймгийн хэмжээнд энэ оны байдлаар 1347 эрсдэлтэй хүүхэд илрүүлсэнээс 94 хүүхдийг эрсдэлийн программд бүртгээд байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдээс 1105 хүүхэд хариу үйлчилгээ үзүүлж, эргэх холбоотой ажилласан. Үүнд: гэнэтийн ослын даатгалд 720 хүүхдийг хамруулсан, 196 хүүхдийн гэрт нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай хэрэгцээт зүйлээр дэмжсэн, 175 хүүхдийн асуудлаар хяналт тавьж эргэх холбоотой ажиллаж, 114 хүүхэд сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлж ажилласан. Мөн эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч 15 иргэнийг ажлын байранд, 19 иргэнийг холбогдох байгууллагуудад холбон зуучилсан. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 87 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	Олон нийтийн байцаагч нарыг ажиллуулахаар Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газартай зөвшилцөөд байна.	хэрэгжсэн
НИИТ									
3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:									
4.1.	"Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	-	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна.	5,000,000	Улсын төсвө	Аймгийн хэмжээнд 132 байгууллага Хүүхэд, хамгааллын бодлого батлан хэрэгжүүлж, бодлого хэрэгжүүлж буй байгууллагын тоо өмнөх оноос 26.8 хувиар өссөн байна. Энэ нь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт байгууллагын 61.6 хувийг эзэлж байна. Цаашид нийт байгууллагыг Хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийг уриалж, сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулж байна.	-	хэрэгжсэн

1.4.2.	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо		Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	1347	27,500,000	Улсын төсөв	Аймгийн хэмжээнд 0-18 насны хүүхэд 43332 байгаа нь нийт хүн амын 37.5 хувийг эзэлж байна. Эдгээр хүүхдүүдээс бүтэн өнчин хүүхэд 116, хагас өнчин хүүхэд 1529 байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 1347 хүүхдийн судалгааг гаргаж эрэмблэхэд өндөр эрсдэлтэй 197, дунд эрсдэлтэй 340, бага эрсдэлтэй 455, эрсдэлд өртөх магадлалтай 355 хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдийг хүйсээр ангилвал эмэгтэй 756, эрэгтэй 591 хүүхэд байна. Өндөр болон дунд эрсдэлтэй ангилалд бүртгэгдсэн хүүхдүүдээс 720 хүүхдийг хүүхдийн эрсдэлийн даатгалд хамруулж, хяналт тавин ажиллаж байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдээс 1105 хүүхэд хариу үйлчилгээ үзүүлж, гэнэтийн ослын даатгалд 720 хүүхдийг хамруулсан, 196 хүүхдийн гэрт нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай анхан шатны хэрэгцээг хангаж дэмжлэг үзүүлээд байна. Бүтэн өнчин болон анхаарал халамж шаардлагатай 175 хүүхэд, тэдний гэр бүлд хяналт тавьж, эргэх холбоотой ажиллаж байна. Энэ жилд 114 хүүхэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн асран хамгаалагч 15 иргэнийг түр болон бүр ажлын байранд, 19 иргэнийг холбогдох байгууллагуудад холбон зуучилж шаардлагатай үйлчилгээ үзүүлээд байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 126 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс 86 дуудлага мэдээллийг хариу үйлчилгээний программд хааж, шийдвэрлэлт 80,7 хувьтай байна. Бүртгэгдсэн дуудлага, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 буюу 42 хувиар өссөн нь хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд шинээр томилогдсонтой холбоотой илрүүлэлт нэмэгдэж, кейсийн цар хүрээ өсч, үйл ажиллагаа бүрэн хийгдсэн байна.	хэрэгжсэн
4.3.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;	450,292.9	1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь	26.7 хувь	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.		29,000,000	ОУБ-ын санхүүжилт	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, түүний ажлын алба нь 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 61 хүүхдэд үйлчилгээ үзүүлснээс гэмт хэргийн хохирогч 31, зөрчлийн хэргийн хохирогч 6, гэрч 10, холбогдогч 3, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 11 хүүхэд хамгааллын болон холбон зуучлах, эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээг давтамжтай үзүүлсэн байна. Бэлгийн хүчирхийллийн хохирогч 10 хүүхдэд сэтгэл зүй, хууль эрх зүй, эрүүл мэндийн, боловсролын үйлчилгээг үзүүлж, 2 хүүхдийг хүүхдийн ордны дэргэдэх илтгэх урлагийн дугуйланд, Насан туршийн суралцахуйн төвд холбон зуучилж, хөгжлийн үйлчилгээнд хамруулаад байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч шүүх, цагдаагийн байгууллагаас ирсэн албан бичгийн дагуу шүүх хурал болон мэдүүлэг авах ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, тэдний эрхийг хамгаалж, хууль ёсны төлөөлөгчөөр 43 удаа оролцож ажилласан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын төлөвлөгөөнд "Хүүхдээс мэдүүлэг авах өрөө" –г шинээр байгуулж, тохижуулахаар төлөвлөсний дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэд Дэлхийн зөн олон улсын байгууллагын 29,0 сая төгрөгийн санхүүжилтээр тус өрөөг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдүүдийн эрхийг хамгаалж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан үр дүнтэй ажил болсон.	хэрэгжсэн

1.4.4.	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих;		1.Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь		Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна.	6 100	100,000	Улсын төсөв	Аймаг, сумдын баяр наадмын хурдан морины уралдааны үед уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандартын хэрэгжилт, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангуулж, уралдааны замд хяналт тавьж, 1117 уралдаанч хүүхдийг able программд бүртгэх ажлыг зохион байгуулан, унаач хүүхдийн хамгаалах хувцас хэрэгслэлийг бүрэн шалгаж, замд гаргасан. Уралдааны явцад богино холбоо ашиглахаар хүүхдийн биед төхөөрөмж багласан, хэт урт ташуур хэрэглэх зэрэг 36 зөрчлийг илрүүлж, таслан зогсоосон. Хүүхдийн эрхийн Улсын байцаагч, аймгийн баяр наадам зохион байгуулах хурдан морины комисстой хамтран уралдааны замыг урьдчилан шалгаж хяналт тавьж, замын чулуу, бусад тээглэх зүйлийг холдуулах, үлийн нүхийг даруулах ажлыг хийж, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангахад анхаарч ажилласан. Бүртгүүлсэн хүүхэд солигдох, 8 нас хүрээгүй хүүхэд морь унах, 1 хүүхэд өдөрт 2-оос дээш насны морь унаж уралдаж байгаа эсэхэд хяналт тавьж, уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалж, цахим мэдээллийн санд орсон зураг, мэдээлэлтэй хүүхэд бүрийг тулган шалгаж, уралдааны замд гаргасан байна. Мөн аймаг, сумдын баяр наадам зохион байгуулах комиссоос мэргэжлийн байгууллагуудтай хамтран уяачдын галаар тойрч холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам стандартыг танилцуулж, 212 уяачдын галаар 3 удаа тойрч, 175 уяач, 200 гаруй уралдаанч хүүхдэд мэдээлэл хийж, зөвлөмж өгсөн байна. Баяр наадмын өмнө уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, уралдаан, сунгаа, үсэргээс болох зам, орчны аюулгүй байдалд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах тухай 01 зөвлөмжийг хүргүүлж, сумдын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн тэргүүн, Морин спорт уяачдын холбоодын тэргүүн нарт	хэрэгжсэн
4.5.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;		1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо	MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	15000 иргэн 1700 хүүхэд 15000	12,000,000	Улсын төсөв	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллыг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: гамшиг онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалж, тусламж дэмжлэг үзүүлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын ерөнхий төлөвлөгөө, газар хөдлөлтийн гамшгийн үед гэр бул, хүүхдийг хамгаалах хариу арга хэмжээ авах төлөвлөгөө, хүн ам нийгмийн хамгааллын салбарын гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө, гамшгийн эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө зэрэг 4 төрлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийн хүрээнд 4 байгууллагын хамтарсан "Хүүхэд хамгаалалд-бидний оролцоо" нэгдсэн удирдамжийн дагуу ерөнхий боловсролын 13 сургуулийн 1700 хүүхэд, 250 төрийн албан хаагчид сургалт мэдээлэл түгээж, "Анхны тусламж амь насыг аварна" сэдэвт гар зургийн уралдаан, "Гамшгийн эрсдлийг бууруулахад миний оролцоо" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Хүүхдийг болзошгүй аюул, осол гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 сумын 15 цэг байршилд хяналт тавьж, 200 гаруй иргэнд мэдээлэл түгээн, 7 төрлийн брошурыг тарааж, цахим сүлжээнд 1900 гаруй иргэнд	хэрэгжсэн
6.	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд эзлтэй орчин бүрдүүлэх;		Осол гэмтлийн буурсан хувь		Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд эзлтэй орчин бүрдүүлсэн байна.		7,300,000	Улсын төсөв	"Хүүхэд хамгаалалд бидний оролцоо", "Аюулгүй орчин-Аз жаргалтай хүүхэд" үйл ажиллагааг зохион байгуулж цахимаар болон биечлэн 1500 иргэнд хүүхдийг болзошгүй аюул, осол гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх хүрээнд мэдээлэл өгч, Онги, Орхон, Таацын гол, Улаан цутгалан зэрэг 10 гаруй цэг байршилд очиж ажилласан байна. Мөн аймгийн төвийн болон сумдын 59 тоглоомын талбайд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй 14 талбайг холбогдох газарт мэдэгдэж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч байна. Хүүхдийг ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн гарын авлага, постер бэлтгэн иргэд, гэр бүлүүдэд тарааж, мэдээлэл түгээж байна. Эрсдлийг арилгуулж, эргэж мэдэгдэх чиглэлээр Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ОНӨҮГ, Онги-Ус суваг ОНӨААТҮГ газарт албан бичиг хүргүүлж уламжилнаас дээрх байгууллагууд хариу арга хэмжээ авч эрсдэлийг 100 хувь арилгасан байна.	хэрэгжсэн

4.7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.		Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь	Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна.	4,500,000	Улсын төсөв	Хүүхэд оролцсон уралдаан, тэмцээн, дугуйлан, сургалтын бэлтгэл сургуулийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ын танилцуулга сургалтыг зохион байгуулж, Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа дугуйлан, сургалтын 40 гаруй багш, албан хаагчид, төр болон төрийн бус байгууллагуудтай санамж бичиг байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн сумдын хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхдийн элч нарт журмын танилцуулга мэдээллийг өгч, чиглэл хүргүүлж, зохион байгуулагдсан спортын болон урлагийн нийт 20 гаруй тэмцээн, уралдаан журмын дагуу зохион байгуулагдаад байна. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулж болзошгүй 70 гаруй газарт хяналт хийж, 2 хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлсэн байна. Худалдаа үйлчилгээ эрхлэгч 35, зочид буудлын үйлчилгээ 5, бар ресторан 8, барилга байгууламж 15, авто угаалга 4, авто засварын 3 газарт хяналт хийж, ажил олгогч нарт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээлэл өгч, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж тараалаа. Хүүхдийн эрхийн улсын байцаагчаас 2025 онд MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага, MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдалд ерөнхий шаардлагуудын хэрэгжилтийн байдал хяналт тавьж, Хужирт сумын ерөнхий боловсролын 1,2 дугаар сургуулийн дотуур байрын стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд 01, 02 дугаартай албан шаардлагыг хүргүүлснээр 2021, 2023 онд хийсэн хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 154,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахилгааны монтажийг иж бүрэн сольж, 1 дүгээр сургуулийн дотуур байрын гудас, хөнжлийг шинэчилсэн. Хархорин сум дахь хүүхдийн хөгжил, хамгааллын "Солонго" асрамж халамжийн төвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 2025	хэрэгжсэн
НИЙТ								

Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;

3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:

1.	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах;		Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан.	ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	5 124	0.0	улсын төсөв	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөр нийгмийн гурван талт хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм, журмыг сурталчлан таниулах танхимын сургалтыг 124 удаа зохион байгуулж, 5 салбарын 366 байгууллагын 3164 ажилтан, иргэнийг тус тус хамруулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс иргэдийн оролцоотой нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь аюул эрсдэлийг илрүүлж, арилгах зорилготой, иргэд мэдээлэл оруулахад хялбар шийдэл бүхий "Эрсдэлээс сэргийлье" гар утасны аппликэйшнийг 19 суманд нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд 174 эрсдэл бүртгэгдсэнийг холбогдох байгууллагад шилжүүлж, шийвэрлэгдсэн 60 буюу 34.4 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн
2.	Орон нутаг дахь бичиг, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	2,074,121.9	1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо		Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна.	153 0	6,6 сая төгрөг	улсын төсөв	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт ирүүлсэн Хужирт сумын "Элма Хужирт", "Сэмжид хужирт" рашаан сувилалд зөвлөх үйлчилгээг үзүүлсэн. Тус байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, гомдол шийдвэрлэх журам, ажилтны мэдээлэл авах, боловсруулах, хадгалах, ашиглах журмыг шинээр боловсруулж, зарим албан бичигт нэмэлт өөрчлөлт оруулан, ажил олгогч, ажилтны хоорондын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны зөв соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомжуудыг хэрэглэх, хуулийн хэрэгжилтийн талаар танхимын болон цахим, утсаар зөвлөгөө мэдээлэл өгч эргэх холбоотой ажиллаж, зөвлөх үйлчилгээний зардалд хөдөлмөр, эрхлэлтийн дэмжих сангаас 6.6 сая төгрөгийг зарцуулсан.	Хэрэгжсэн

2.1.3.	Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо	Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна.	1	0.0		Арвайхээр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, шинэчлэн батлуулж дүрэм, журмыг гишүүдэд танилцуулсан. Тус хороонд нийт 7 хөдөлмөрийн эрхийн маргаантай холбоотой гомдол хүлээн авч танилцах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: 3 гомдлыг маргаан урьдчилан шийдвэрлэх журмаар харилцан тохиролцож эвлэрүүлсэн, 3 маргаан гаргагч харилцан тохиролцоогүй тул хурлын тэмдэглэл үйлдэж баталгаажуулан талуудад хүлээгдэн өгсөн, 1 маргааныг хүлээн авч бүртгэн комиссын гишүүдэд танилцуулж ажилласан.		Хэрэгжсэн
2.1.4.	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах.	Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна.	1	0.0		Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийг (2023-2025) байгуулан аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт салбар хороогоор батлуулж, хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, аймгийн хамтын хэлэлцээрт нийцүүлэн ажил олгогч, ажилтнууд тохиролцож хамтын гэрээ байгуулах талаар хууль тогтоомжийн талаарх мэдээлэл зөвлөгөөг 25 байгууллагад өгсөн. 2025 онд Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1,2,4 дүгээр сургууль, Мэргэд сургууль зэрэг байгууллагууд хамтын гэрээг шинээр байгуулж, хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн.		хэрэгжсэн
НИЙТ										

3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:

2.1.	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;	1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо	Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр	Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна.	1 2			Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлох зорилгоор хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалт төлөвлөлтийн хэлтэс, хүнс, хөдөө аж ахуйн газар зэрэг байгууллагуудаас 2025 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалт, орон нутгийн онцлогтой, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эхлэх 68 ажил олгогчдын судалгааг нэгтгэн гаргасан. 2025 оны 11 дүгээр сарын 24-ны байдлаар Арвайхээр, Есөнзүйл, Сант сумдад орон нутгийн онцлогтой, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12 үйлдвэр үйлчилгээний салбар шинээр бий болсон байна. Бий болсон ажлын байрыг хөдөлмөр эрхлэлтийн ejob системд бүртгэсэн. Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумдад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч болон шинээр үйл ажиллагаа эрхэлж буй 71 аж ахуйн нэгж, иргэний судалгааг гаргасан бөгөөд газар дээр нь ажлын байрны бүртгэлийг хийж зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны "Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих" арга хэмжээнд орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг олгохоор Засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт санал оруулж, батлуулсан.		Хэрэгжсэн
------	--	---	--	---	--------	--	--	--	--	-----------

2.2.2.	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;
2.3.	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Судалгаа, мэдээллийн тоо	Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан(EJOB систем)	Аймгийн/сум тус бүрээр/ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна.	2			Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааны үр дүнгээс 2025 онд 1150, 2026 онд 1230 ажлын байрны эрэлт үүсэх төлөвтэй байна. Нийт эрэлтийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл мэргэжилтэн буюу дээд боловсролоор олгогддог мэргэжил шаардах 30.6 хувь, мэргэжил шаардахгүй 30.4 хувь, техникийн болон туслах мэргэжилтэн 39.0 хувь байна. Ажиллах хүчний эрэлтийн 60.9 хувь нь байнгын, 36.1 хувь нь улирлын, 3.0 хувь нь түр ажлын байр тус тус байна. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар орон нутгийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээний хүрээнд 1025 шинэ ажлын байр бий болсон. Үүнээс байнгын ажлын байр 328, түр ажлын байр 369, улирлын чанартай 328 ажлын байр байна. Эдийн засгийн салбарын ангилалаар авч үзвэл хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 6.4 хувь, уул уурхай олборлолт 7.6 хувь, боловсруулах үйлдвэрлэл 7.3 хувь, усан хангамж, ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 3.5 хувь, барилга 49.6 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 1.6 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 8.5 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 1.8 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 1.4 хувь, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 2.2 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 2.8 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 1.8 хувь, боловсрол 3.8 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 1.7 тус тус бий болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон байнгын 220 , түр 199 ажлын байрыг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн.	Хэрэгжсэн
1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл 2023 он - Ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 5.3% 2022 он -ядуурлын түвшин хөдөө 35.6%, аймгийн төв 26.1%, сумын төв 30.6%, хөдөө нутаг 41.2%	Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	1,0 тэр бум		улсын төсөв	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээний судалгаа"-г 19 сумын хэмжээнд зохион байгуулж, зорилтот бүлгийн (ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн) 18429 иргэний датаг бүрдүүлсэн. Тус судалгаанд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлсэн. Үүнд: Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 82 иргэнд 450,0 сая төгрөг, малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 40 иргэнд 320,0 төгрөг, аймгийн болон бүсийн шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 5 иргэнд 82,0 сая төгрөг, ахмадын санхүүгийн дэмжлэгт 58 иргэнд 300,0 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох (50 хувийн эргэн төлөлттэй) арга хэмжээнд 35 иргэнд 194,0 сая төгрөгийг тус бүр зарцуулсан байна. Санхүүгийн дэмжлэгийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл оёдол эсгүүр 22 иргэн 114 сая, үсчин гоо сайхан 16 иргэн 87,0 сая, гагнуур төмөр хийц 10 иргэн 62,0 сая, авто засвар 14 иргэн 72,0 сая, хоол үйлдвэрлэл 15 иргэн 84,0 сая, модон эдлэл 12 иргэн 76,0 сая, гар урлал 9 иргэн 55,0 сая, газар тариалан 24 иргэн 124,0 сая, суран эдлэл 7 иргэн 36,0 сая, цагаан идээ боловсруулах 3 иргэн 16,0 сая, бусад 47 иргэн 300,0 сая төгрөгийг олгосон дүнтэй байна.	хэрэгжсэн

2.2.4.	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;	2,664,343.3	1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%, /2023 он/	Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.	3 231.7	231.7	улсын төсөв	Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны 131 иргэнийг ажил хайгчаар бүртгэсэн. Малчдыг малжуулах арга хэмжээнд 3 өрхийг хамруулж 24.0 сая төгрөгийн мал нийлүүлсэн. Мөн мод тарих арга хэмжээнд 50 иргэн хамрагдаж ажиллах хүчний зардалд 13.7 сая төгрөгийг зарцууллаа. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 317 иргэн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох (50% эргэн төлөлттэй) арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 40 иргэнд аж ахуй эрхлэлтийн зээлийн өмнөх болон дараах сургалтыг зохион байгуулж, 35 иргэнд 194,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон. Тус арга хэмжээнд зорилтот бүлгийн иргэдийг хамруулсанаар 41 байнгын, 50 түр ажлын байр бий болсон байна.	Хэрэгжсэн
2.5.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх;		1. Ажилд зуучуулсан иргэний тооны өсөлт 2.Холбогдох арга хэмжээний тоо		Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.		2,000.0	Орон нутгийн төсөв	Төр хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан орон нутагт хөдөлмөрийн бирж шинээр байгуулах хүсэлт гаргасан 2 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дүгнэлт гарган Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. Өвөрхангайн "Мичид төгс наран" хөдөлмөрийн бирж НҮТББ нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх эрх бүхий хөдөлмөрийн биржүүдийн жагсаалтад орж эрх авсан. Эрх авсан хөдөлмөрийн биржид Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг дэмжих туршилтын төслийн талаарх мэдээллийг өгсөн. Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 10 мэргэжилтэн, албан хаагчдыг Хан-Уул, Баянгол, Сүхбаатар дүүрэгт байгуулагдсан "Job center" төвүүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох, чадавжуулах үйл ажиллагаанд хамруулсан.	Хэрэгжээгүй
2.6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих;		1.Хяналт шалгалтын тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо 3.Холбогдох арга хэмжээний тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/ Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян.хүн /2023 он/	Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.	18 11 18		улсын төсөв	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэний санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавин Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Уянга, Хайрхандулаан, Нарийнтээл, Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Арвайхээр сум тус бүрт 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Эргэн төлөлтийг хийх тухай мэдэгдлийг 89 иргэнд өгч 11 дүгээр сарын байдлаар нийт 1166 иргэний 1.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн. Үүнээс хугацаа хэтэрсэн 77 иргэний 69,0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрүүлсэн байна. Шүүхийн байгууллагад 47 иргэний 141,0 сая төгрөгийн авлагын асуудлыг шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргаж хүргүүлсэнээс 29 иргэний 74.7 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.	Хэрэгжсэн
2.7.	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртөй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;		1.Холбогдох арга хэмжээний тоо 2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/н тоо	2023 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан	Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	2 24 107.0 сая 0	107.0	Улсын төсөв	залуучуудад гарааны санхүүжилт олгох, мэргэжлийн менторууд, бизнес эрхлэгчдээс зөвлөгөө авч бизнесээ илүү боловсронгуй болгох боломжийг бүрдүүлж, дараагийн шатны санхүүжилтийг олгох, бизнес санааг нь дэмжих зорилготой "Стартап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох" аймгийн болон бүсийн хэмжээний арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний талаарх мэдээллийгаймгийн цахим хуудсанд байршуулж, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Уянга, Хайрхандулаан, Нарийнтээл, Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Арвайхээр сумдад зохион байгуулагдсан өдөрлөг арга хэмжээний хүрээнд нийт 1000 гаруй иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. Аймгийн шилдэг старт ап сонгон шалгаруулах арга хэмжээний 1 дүгээр шатанд 12 баг өрсөлдсөнөөс 5 багийн бизнес санаа шалгарч дараагийн шатны хурдасгуур арга хэмжээнд хамрагдаж финалд 2 баг шалгарсан бөгөөд тус бүрт 15,0 сая төгрөгийн 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олголоо. Хангайн бүсийн арга хэмжээнд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн 9 багийн 12 залуу оролцон, бизнесийн төслөө танилцуулан өрсөлдсөнөөс I байрт Баянхонгор аймаг /Green cycle/ төсөл, II байрт Өвөрхангай аймаг /Candella brand/ төсөл, III байр Баянхонгор аймаг Goji /цэвэр усны сав/ төсөл тус тус шалгарлаа. Бүсийн хэмжээнд "Стартап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох арга хүрээнд ХЭДС-аас 52.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус арга хэмжээний хүрээнд 8 ажлын байр шинээр бий болсон.	Хэрэгжсэн

2.2.8.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ		1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан.	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	34	2.7 сая төгрөг	2.7	улсын төсөв	Хөдөлмөр эрхлэлтийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан 34 иргэнийг 3 удаагийн яармаг, үзэсгэлэн худалдаанд оролцуулж, түрээсийн дэмжлэгийг үзүүлсэн. Санхүүгийн дэмжлэгт 2023-2025 онуудад санхүүгийн дэмжлэг авсан 47 иргэний бараа бүтээгдэхүүнийг Өвөрхангайд үйлдвэрлэв төвөөр дамжуулан сурталчлан борлуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.	Хэрэгжсэн
2.2.9.	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;		Холбогдох арга хэмжээний тоо	2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд 160.7 сая төгрөг зарцуулсан.	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна.	2	15.5 сая		улс, орон нутгийн төсөв	Хөдөлмөрийн эрхлэлтийн аймгийн зөвлөлийн хуралдааныг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 1 удаа танхим, 1 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. Зөвлөлийн хуралдаанаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг олгох тэргүүлэх чиглэл, малчдыг малжуулах арга хэмжээнд хамрагдах сумдын хуваарь гаргах тухай 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Тус зөвлөлөөс "Малчдыг малжуулах" арга хэмжээнд хамрагдсан малчин өрхүүдийг мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуйн туршлага солилцох уулзалтад хамруулахад аймаг, орон нутгаас дэмжлэг үзүүлэх шийдвэрийг гаргаж БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн хот, Хунчир аймгийн малчдын аж амьдрал, мал маллах арга ухаан, малын ашиг шим боловсруулах туршлага солилцох уулзалт арга хэмжээг зохион байгуулж 22 иргэнийг хамрууллаа. Арга хэмжээний зардалд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 10.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийг зарцуулсан.	Хэрэгжсэн
2.10.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.		1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажил	2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.	Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	31.5	17.5	31,5	улсын төсөв	Арвайхээр, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Хархорин, Өлзийт, Богд, Гучин-Ус, Баруунбаян-Улаан суманд нээлттэй хаалганы өдөрлөгөөр Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ахмадын тухай хуулийн тухай, хэрэгжилт, хууль тогтоомжийн талаар 124 аж ахуйн нэгж, байгууллагын 476 ажил олгогч, ажилтан иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд сургалтыг зохион байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, арга хэмжээнд 58 ахмад настан, 34 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамруулж, 92 ажлын байр хадгалагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал зохих 102 байгууллагад мэдээлэл зөвлөгөө өгч, 2 байгууллагаас 31,5 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.	Хэрэгжсэн
НИЙТ											
3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:											
3.1.	Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх.	2024 оны хэрэгжилт	Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна.		3.0 сая		Орон нутгийн төсөв	Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сурталчлан таниулах танхимын сургалт хэлэлцүүлгийг 9 сумын 366 байгууллагын 3164 удирдлага болон албан хаагч, ажилчдад сургалт зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Дээрх арга хэмжээний гарын авлага болон шатахууны зардалд орон нутгаас 3.0 сая төгрөгийг зарцуулсан. 2025 оны 11 сарын байдлаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газар, Баянтээг ХК-д, Цагдаагийн газарт, Шунхлай ХХК-д нийт 5 үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэн байна.	Хэрэгжсэн
2.	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөлөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	18.0 сая төгрөг	11	18.0	Орон нутгийн төсөв	Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, зөвлөлийн гишүүдийг чадавжуулах сургалт, ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудыг мэргэшүүлэх, сертификаттай сургалтыг эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран танхим болон цахимаар 2 удаа, хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн талаар үзлэг шалгалт, хэлэлцүүлгийг 5 удаа, танхимын сургалтыг 4 удаа зохион байгуулж, 5 салбарын 124 байгууллагын 209 ажилтан, иргэнийг тус тус хамруулж, 1100 гарын авлага, материалыг түгээж ажилласан.	Хэрэгжсэн

2.3.3.	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	2024 оны гүйцэтгэл	Тухай бүр арга хэмжээ авсан байх	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо			Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол бүртгэгдээгүй.	Хэрэгжсэн
НИЙТ										

3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:

4.1.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт3.Гадаад ажилтан	2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн	Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.			Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах хүсэлт 2 ажил олгогчоос ирүүлсэн. Ажлын байрны мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байршуулж, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан.	хэрэгжсэн	
4.2.	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт3.Гадаад ажилтан		Хуулийн хэрэгжилт сайжирсан байна.			зааснаар "гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон харилцаа"-г зохицуулсан чиг үүрэгтэй холбогдуулан Өвөрхангай аймагт оршин сууж байгаа гадаадын иргэдийн товч мэдээллийн тухайд: Ди Ди Жи энд Эйч Жи Си Эм РЕСАЙКЛИНГ Монголиа ХХК нь Марокко улсаас 1 иргэнийг "Химийн инженер" ажлын байранд ажиллуулж байна. "С буюу хөдөлмөр эрхлэх", ангиллын оршин суух зөвшөөрөлтэй 9 (БНХАУ-3, Филиппин-2, БНСВУ-3, Япон-1), "F буюу гэр бүлийн" ангиллын оршин суух зөвшөөрөлтэй 2 (Бүгд Найрамдах Польш Улс -1, Бүгд Найрамдах Солонгос Улс-1), "J буюу Шашны" ангиллын оршин суух зөвшөөрөлтэй 5 (Кени-3, Этиоп-1, Танзани-1) гадаадын иргэд	хэрэгжсэн	
НИЙТ										

Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.3.1. Нийгмийн даатгалын талаар:

1.1.	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах;		Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он-152 800	Сайн дураар даатгуулагчийн тоог багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	6 хувь	-	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Ажил олгогч, иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар болон нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, сайн дурын даатгал, цахим үйлчилгээтэй холбоотой мэдээллээр нийт 218 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 21880 иргэд даатгуулагч хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид болон Политехник коллежийн оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулахаар "Даатгалтай ирээдүй" сургалтыг нийт 15 удаа зохион байгуулж, 624 төгсөх ангийн сурагчид болон оюутнуудыг хамруулсан. Жилийн эцсийн байдлаар явуулын үйлчилгээ-21, нээлттэй хаалганы өдөрлөгийг 14 удаа зохион байгуулж нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, талаар мэдээлэл өгсөн. Давхардсан тоогоор нийт 10489 иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажилласнаар сайн дурын даатгалд жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1455 даатгуулагчийг шинээр хамруулж үүнээс малчин, туслах малчин, сайн дурын даатгалд 968 малчин даатгуулагч, 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй ажил хөдөлмөр эрхлээгүй эх эсхүл эцэг сайн дурын даатгалд 78, 0-3 насны хүүхдээ асарч буй 73 даатгуулагч эх, энгийн сайн дурын даатгалд 336 даатгуулагч хамруулахаар байв.	Хэрэгжсэн
------	---	--	--	---	--	--------	---	---	---	-----------

3.1.2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	
3.1.3.	Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;	1,835,146.2
1.4.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;	

Цахим хэлбэрт шилжүүлсэн хувийн хэргийн эзлэх хувь	-	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна.				Аймгийн хэмжээний нийт 20482 тэтгэвэр авагчдын хувийн хэргийг бүрэн цахимжуулж энэ онд шинээр тогтоогдож буй хувийн хэргийг тухай бүр нь цахимжуулж хэвшсэн. Мөн ажилгүйдлийн тэтгэмж болон тэтгэмжийн даатгалын даатгуулагчийн өргөдлийг https://portal.ndaatgal.mn/ -ээр цахимаар авч хэвшсэн. Жилийн эцсийн байдлаар 4434 тэтгэмж олгосоны 3328 даатгуулагчийн хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэсэн.		Хэрэгжсэн
Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо - 848				Өмнөх оны жилийн эцсийн байдлаар 660,5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай гарсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 27 байгууллагын 627,0 сая төгрөг буюу урьд оны авлагын 94,9 хувийг барагдуулсан бөгөөд барагдаагүй болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн 3 байгууллагын 33,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй 5,1 хувийг барагдуулаагүй байна. "Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах" жил болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах, хамралт нэмэгдүүлэх уралдаант аян зарлаж уг аяны хүрээнд хуримтлагдсан болон тухайн саруудад үүссэн шимтгэлийн өр авлага барагдуулах талаар шүүхэд нэхэмжлэл гаргасан 6, өр авлага барагдуулах тухай албан тоот 39, уулзалтын тэмдэглэл хөтөлж уулзалт зохион байгуулсан 46, гэрээ график байгуулсан 34, шимтгэлийн өр төлбөрөө барагдуулах улсын байцаагчийн албан мэдэгдэл 14, 55 аж ахуйн нэгж байгууллагын данс хаах арга хэмжээ авч ажилласнаар нийт 2.228.5 сая төгрөгийн авлага барагдуулсан байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар төсвийн 1 байгууллагын 268,6 сая төгрөгийн өр авлагатай гарсныг бүрэн барагдуулсан. 2025 онд БОЭТ, бусад сум өрхийн эрүүл мэндийн болон сургууль цэцэрлэг, соёлын төвийн зэрэг боловсролын байгууллагууд санхүүжилт хүрэхгүй гэсэн шалтгаанаар сар бүр 800,0-900,0 сая төгрөгийн шимтгэлийн өртэй гарч байгаа нь өр авлагын 70-80 хувийг эзэлж байна. 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 16 аж ахуйн нэгж байгууллагын 450,3 сая төгрөгийн авлагатай гарахаар байна.		Хэрэгжсэн
Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алсан иргэдийн тоо 102446	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна.				Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 13 удаагийн сургалтаар нийт 2015 иргэнд мэдээлэл хүргэн, сум өрхийн эрүүл мэндийн төвийн сэргээн засах тусламж үйлчилгээнд 4210, орон нутгийн рашаан сувилалд 742 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл энэ онд 47 удаагийн хуралдаанаар 3887 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлэсэн байна. Үүнээс шинээр 338, сунгалт хийсэн 3267, шилжиж ирсэн 6, шилжиж явсан 15, цуцалсан 198, нас барсан 63 иргэн байна. Урьд онтой харьцуулахад хөдөлмөрийн чадвар алдалт тогтоосон 91 иргэнээр буурсан байна Хөдөлмөрийн чадвар алдалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар буурсан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт 3151 иргэн байгаа бөгөөд энэ нь аймгийн нийт хүн амын 3,1 хувийг эзэлж байна.		Хэрэгжсэн

3.1.5.	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах.		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаагаар болсон байна.					Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх журам"-ын хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмын 1.3 "Төв байгууллага нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.6-л заасан	
НИЙТ											

3.3.2. Нийгмийн халамжийн талаар:

2.1.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо	-	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна.	22 бүл	39.6	Орон нутгийн төсөв	"Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар" батлагдсантай холбогдуулан орон нутгийн төсвийн санхүүжилтээр, хэрэгцээ шаардлагад үндэслэн тендер зарласан. Тендерт "Улаан загалмайн хороо" шалгарч, дараах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа шаардлагатай, амьжиргааны түвшин доогуур өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төслийг хэрэгжүүлэх, амьдрах ухаанд суралцах, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, санхүүгийн боловсрол олгох чиглэлийн сургалтад 50 иргэнийг хамруулсан. Мөн төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах асуудлаар арга зүйн зөвлөгөө өгч, 22 бүлийн төслийг дэмжин, нийт 43,0 сая төгрөгийн санхүүжилтээр тусалцаа үзүүлэн ажиллаж байна.		Хэрэгжсэн
2.2.	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтлоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо	-	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтлоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.				Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн болон хорих ангиас суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх, архины хамаарлаас гаргах эмчилгээ, үйлчилгээ, сэтгэл заслын сургалт арга хэмжээг "Оточгаргалан" ХХК гэрээлэн гүйцэтгэж үйлчилгээнд 18 иргэнийг хамруулсан.		Хэрэгжсэн
2.3.	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавжуулах сургалтад тогтмол хамруулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо,	-	Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадва сайжирсан байна.	1			Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны аргачлал, арга зүйн тухай сургалтыг 13 багийн нийгмийн ажилтнуудад зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газраас зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дадлагажуулагчаар бэлтгэх сургалтад 8 албан хаагч хамрагдсан. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан "Сурьезд өртсөн хүмүүс болон тэдний гэр бүлд нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээ үзүүлэх нь" сэдэвт сургалтад тус байгууллагын нэг албан хаагч хамрагдлаа. Мөн Эрүүл мэндийн газрын албан хаагчид болон өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувиллагч нарт хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний талаар сургалт зохион байгуулсан.		Хэрэгжсэн
НИЙТ											

3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тааар:

3.3.1.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	1,304,664.2	Сургалт	-	30-аас доошгүй	8	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор 16 удаагийн сургалт, арга хэмжээнд 658 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Үүнд: 9 суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж "Хөгжлийн бэрхшээл ба хууль эрх зүйн орчин" сэдвээр 485 иргэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагддаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд болон тэднийг асардаг иргэдэд зориулан 6 удаагийн сургалаар 140 иргэнийг тус тус хамруулсан. "Цагаан таягтны өдөр"-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 28 иргэнд, цагдаагийн газрын 53 албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй онцлог хэрэгцээнд нь нийцүүлэн хэрхэн харилцаж, үйлчилгээ үзүүлэх талаар сургалт, зөвлөгөөг тус тус өгч ажилалласан.	Хэрэгжсэн
3.3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	20		Орон нутагт Сонгуулийн тухай хуулиар энэ онд 2 тойрогт нөхөн сонгууль явагдсан. Сонгогдох, сонгогдох эрхийн талаар залуу сонгогчдын сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх, сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай сонгогч" сургалтыг орон нутгийн иргэдийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулагдах Нарийнтээл сумын төвд Сонгуулийн ерөнхий хорооны орон нутаг дахь сургагч багш нар 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж ажилласан. Тус сургалтад Нарийнтээл сумын Ерөнхий боловсролын 12 дугаар ангийн сурагчид болон Баянтээг багийн 18-25 насны залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл хамрагдан, хариуцлагатай сонгогчийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж ажиллав.-	хэрэгжсэн
3.3.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах;		Зохион байгуулсан сургалтын тоо	-	3		Орон нутгаас нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургагч төрийн байгууллагад 2, төрийн бус байгууллагын 2 сургагч багш бэлтгэгдсэн. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн насны хүн амд зориулсан явуулын амбулаторийн үзлэг зохион байгуулж, 1444 зорилтот насны иргэд хамрагдсан бөгөөд 5-6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Үзлэгт хамрагдсан иргэдэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, халдварт халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн	Хэрэгжсэн
3.4.	Байнгын шаардлагатай бэрхшээлтэй хөгжүүлэх дэмжих ажлыг байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих төв	-	1	Аймгийн хэмжээнд 0-18 насны 583 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Үүнээс 0-5 насны 110, 6-18 насны 473 хүүхэд байна. Мөн боловсролын үйлчилгээнд дараах байдлаар хамрагдаж байна. Үүнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 61, ерөнхий боловсролын сургуульд 323, насан туршийн боловсролын төвд 27, политехникийн коллежид 4 хүүхэд хамрагдаж байна. Арвайхээр сумын 11 дүгээр цэцэрлэг нь байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэн, дэмжиж сургах үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд нийт 37 хүүхдийн энэ үйлчилгээнд хамруулж байна. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төв буюу орон нутагт цэцэрлэг баригдаж байгаа бөгөөд барилгын гүйцэтгэл 95 хувьтай явагдаж байна.	Хэрэгжсэн	

3.3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	2	19		Орон нутгийн төсөв	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Тайлант хугацаанд салбар комисс 21 удаагийн ээлжит хурал, 4 удаагийн ээлжит бус хурал, 2 суманд нүүдлийн хурал зохион байгуулсан. Ээлжит хурлаар 327 хүүхдийн асуудлыг хэлэлцэн, 10 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг цуцалж, 7 хүүхдийг заалт тохирохгүй, онош тодруулах шалтгаанаар буцааж, 1 хүүхдийг 18 нас хүрсэн тул эрүүл мэндийн магадлалын зөвлөлд илгээж, 309 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон. Үүнээс 61 хүүхдэд байнгын асаргаа шинээр тогтоож, 209 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийг 32 хүүхдэд тогтоож, 7 хүүхдийг нийгмийн халамжийн бусад хөнгөлөлтөд хамруулахаар шийдвэрлэв. Хөгжлийн бэрхшээлээ тодорхойлуулсан 309 хүүхдээс сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 54, ерөнхий боловсролын сургуульд 178 хүүхэд суралцаж байна. Боловсролын үйлчилгээнд хамрагдах насанд хүрээгүй 0-2 хүртэлх насны 22 хүүхэд байгаа бол боловсролын үйлчилгээнд хамрагдах шаардлагатай 55 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдээ боловсролын үйлчилгээнд хамруулах чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч, холбогдох байгууллагуудад мэдээллийг хүргэж ажиллалаа. Ээлжит бус хурлаар Эрүүл мэндийн сайд болон ГБХЗХ-ны сайдын А/68, А/62 дугаар тушаалаар батлагдсан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох шалгуурын дагуу 456 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 118 хүүхдийг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлон асран хамгаалагчдад мөнгөн тэтгэмжийг нөхөн олгов.		Хэрэгжсэн
3.6.	Орон нутгийн гамшаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100				Сумдын гамшаас хамгаалах сайн дурын хэсгийг чадавхжуулах дадлага сургуулийг 7 суманд зохион байгуулж, цахим сургалтад 228 иргэнийг хамруулсан. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар Онцгой байдлын газраас 2559 мэдээлэл бэлтгэн 1 телевиз, 3 сайт, нийгмийн сүлжээгээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.		Хэрэгжээгүй
3.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5				Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр 9 удаагийн сургалт зохион байгуулж, 200 гаруй эцэг эх хамрагдсан байна. Мөн 11 дүгээр цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд нөлөөллийн хөтөлбөрийн хэрэгжүүлэн ажиллаж байна.		Хэрэгжсэн
3.8.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	-	3				Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд 103 аж ахуйн нэгж, байгууллагад 207 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахаас 163 иргэн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийг 2 байгууллага 31,5 сая төгрөг төвлөрүүлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо болон Бүтээлч гар нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. хуулийн хэрэгжилтийн хүрээнд Арвайхээр Хархорин хужирт сумдад үйл ажиллагаа явуулж буй төрийн болон аж ахуйн нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 2 иргэнийг ажлын байраар хангаж, 2 аж ахуйн нэгж байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах аман гэрээ байгуулсан.		Хэрэгжсэн

3.9.	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	-	5		Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад хүртээмжтэй мэдээллийг хүргэж ажиллахад арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд нийгмийн наад захын үйлчилгээнд хамрагдахад тулгарч буй асуудлын талаар 2 төрлийн цахим контентийг UNN.mn цахим сайттай хамтран бэлтгэж, хуулийг сурталчлан, иргэдийг мэдээллээр хангаж ажилласан бөгөөд хандалтын тоо 2800 байна. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Хурдан" клубыг байгуулж, сумдад иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэхээр бэлтгэгдсэн сургагч багш нар ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдад сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулан нийт 8000 гаруй иргэнийг хамруулсан.	орон нутагт дохионы хэлмэрч дутагдалтай	Хэрэгжээгүй
3.10.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	23.7 сая		Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд 20,8 сая төгрөгийг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эх хүүхдийн эрүүл мэндийн төвтэй хамтарсан үзлэг зохион байгуулж тархины саа саажилт, уналт таталттай 28 хүүхдийг хамруулсан. Спортоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмд зөв таниулах ажлын хүрээнд Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 20 сурагчийг Эрзэн хотод жюу цү-ийн өдөрлөг арга хэмжээнд хамруулав. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.1-д заасны дагуу ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу тохирох хэрэглэгдэхүүнээр хангасан эсэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил хүний эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж нөхцөл, хөдөлмөр эрхлэх боломжоор хангуулж байгаа эсэхэд үзлэг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар удирдамж, төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд 25 дээш ажилтантай 100-102 аж ахуйн нэгж, байгууллагуудад албан бичгээр болон танхимын сургалтаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Мөн хуулийг хүртээмжтэй сурталчилан таниулах ажлын хүрээнд браиль хэвлэлийг бэлтгэн 19 сумын Засаг даргын тамгын газар болон төрийн байгууллагуудад хүргүүлсэн. Төрийн албан хаагчдад дохионы хэлний мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, нийт 16 сум, 20 гаруй байгууллагын 54 албан хаагчид мэдлэгтэй болж, сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах чадамжтай болсон.		Хэрэгжсэн
3.11.	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв	-	3		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр 26 байгууллагын 470 гаруй албан хаагчдад сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн аймгийн хэмжээнд Хүртээмжийг цогцоор нь шийдсэн аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах аяныг зарлаж 10 аж ахуйн нэгж, байгууллага тус аянд нэгдэж хүртээмжтэй орчин бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, нэг цэгийн үйлчилгээний төвийн орчны хүртээмж бүрэн хангагдсан, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын орчны хүртээмж 70 хувь хангагдсан байна.		Хэрэгжсэн
3.12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах.	-	Хөгжлийн төвийн тоо	-	1		Улсын төсвийн 4,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр суманд баригдаж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. Барилгын каркас угсралт, цонх, гадна, дотор хаалга, дээвэр, гадна фасадны ажил хийгдэж дууссан. Дотор засал болон шилэн фасадны ажил хийгдэж байна. 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.		Хэрэгжсэн

НИЙТ													
------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:

3.4.1.	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Сургалт, мэдээллийн тоо 2.Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	-	5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.	6 5	0	Орон нутгийн төсөв	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031), хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн хүрээнд Жендерийн салбар хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, сумдын дэд зөвлөлд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Цагдаагийн газрын албан хаагчдад жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 4 байгууллага, салбарын 80 гаруй ажилтан, албан хаагч оролцлоо. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Харилцан хүндэтгэе" аянд төрийн 19 байгууллага, 8 аж ахуйн нэгж, 13 сум идэвхтэй оролцож, аянд нэгдэж буйгаа илэрхийлж, аяны нэр, уриа бүхий постер, хүрээг ашиглан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, иргэд, албан хаагчид, эцэг эхчүүдийн төлөөлөл 420 гаруй хүн хамрагдаж мэдээлэл авлаа.	Хэрэгжсэн			
НИЙТ													

3.3.5. Ахмад настны талаар:

5.1.	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2	-	Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	8 удаагийн сургалтад 485 иргэн хамрагдсан.			Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Хархорин, Өлзийт, Гучин-Ус, Богд, Баруунбаян-улаан сумдад зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр "Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулга"-аар 485 иргэнд сургалт зохион байгуулж ажилласан. "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ, гэрээр асрамжлах үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор телевизийн мэдээ бэлтгэн Өвөрхангай аймгийн UNN.mn цахим сайт болон Монголын үндэсний олон нийтийн телевизийн MNB мэдээний сувгаар нийтэд хүргэсэн. Мөн нийгмийн халамжийн сангаас ахмад настанд олгож буй тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн талаар 16 удаагийн мэдээллийг 800 гаруй хүнд хүргэсэн. Ахмадууд бол халамж, асрамж хүртэгчид биш, ахмадууд бол хөгжлийг түүчээлэгчид, баялаг бүтээгчдийн үлгэр дуурайлал, чиглүүлэн манлайлагчдийн хувьд залуу, дунд үеийнхэнд хандаж "Алтан сургамж" эссэ бичлэгийн уралдааныг ахмадуудын дунд зарлаж одоогийн байдлаар 20 гаруй бичлэг, захидлууд ирээд байна. Ахмад настны тухай шинэчилсэн хууль, холбогдох дүрэм журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд 8490 гаруй ахмадуудыг хамруулсан байна.	Хэрэгжсэн
5.2.	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, 2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө	Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо	ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна.				Аймгийн хэмжээнд Ахмад настны хуулийн дагуу "Ахмадын сан" -тай 42 аж ахуйн нэгж байгууллага байна. энэ жил шинээр 2 байгууллага ахмадын сантай болсон байна. Аж ахуйн нэгж байгууллага бүр ахмад ажилтныг "Тэтгэвэрт бэлтгэх" төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх чиглэлээр гарын авлага бэлтгэн түгээсэн бөгөөд 16 байгууллага төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.	Хэрэгжсэн

3.5.3.	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо	Нийт ахмадын 60%	20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна.		Жил бүр аймгийн Ахмадын хороотой хамтран ажиллах гэрээ байгуулан ахмад настны хөгжил оролцоо, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр 191,0 сая төгрөгийн санхүүжилт орон нутгаас шийдвэрлэж ахмадын хороо болон үйл ажиллагаа явуулах, нийгмийн оролцоог хангах боломжийг шат дараатай бүрдүүлж байна. Ахмад настны ая тухтай орчинд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх, нийгмийн амьдралын зэрэг зан үйл,зөв хэвшилд суралцахад нь чиглэсэн ахмадын баясах өдөр, хий дасгал, цэнгээнт бүжгийн сургалт, хөгжил оролцооны арга хэмжээнд нийт 8677 ахмадыг хамруулсан. Аймгийн уламжлалт нийтийн цэнгээнт бүжгийг түгээн дэлгэрүүлэх сурталчлах, бүжгээр хичээллэх сонирхолтой ахмадуудыг дэмжих, иргэдэд урлагийн мэдрэмж, гоо зүйн мэдлэг олгох, бүжгийн хөдөлгөөнөөр эмийн бус аргаар эрүүлжих чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн олон талт хамтын үйл ажиллагаа зохион байгуулж, ахмадын өргөөгөөр 4500 гаруй ахмад үйлчилүүлсэн байна.		Хэрэгжсэн
3.5.4.	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан тоо	-	Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.		Идэвхтэй насжилтыг дэмжих төв нь 2025 оны 11 сарын байдлаар лавлагаа мэдээллийн үйлчилгээнд 110 үйлчилгээнд ахмад, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 199, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд 95, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээнд 27 ахмад настныг тус тус хамруулсан дүнтэй байна. Аймгийн ахмадын хороо ТББ Ахмад настны хувилбарт үйлчилгээ үзүүлэх тендерийн "Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлэх" тендерт шалгарч ажил, үйлчилгээ явуулах эрх авч гэрээ байгуулсан. Уг гэрээний хүрээнд Арвайхээр суманд зөвлөгөө мэдээллийн үйлчилгээг 120, зөвлөгөө өгөх үйлчилгээг 80, сайн дурын үйлчилгээг 50, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээг 150, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах үйлчилгээг 5, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ 150, ахмадыг хамруулаад байна. 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөрт багтаан нийт 555 ахмад настанд үзүүлэхээр нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд ажиллаж байна		Хэрэгжсэн
.5.5.	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо	-	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна.		Аймгийн хэмжээнд эрт, илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, ахмад настны цогц үнэлгээ хийх ажлыг эрчимжүүлэх зорилгоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дунд "Анхан шат ба урьдчилан сэргийлэлт" 2 сарын аяныг зохион байгуулж, 7 хоног бүр цахим линкээр мэдээ авч, үр дүнг тооцон ажиллаж байна. Аяны үр дүнд нийт 2924 ахмадыг цогц үнэлгээнд хамруулахад 1-р түвшин 1512, 2-р түвшин 1148, 3-р түвшин 264 ахмад байна. Үнэлгээнд хамрагдсан ахмад настуудаас лавлагаа мэдээллийн үйлчилгээнд 1668, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 495, өдрийн үйлчилгээнд 595, сайн дурын үйлчилгээнд 262, өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээнд 465, асаргааны хувилбаот үйлчилгээнд 202, хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 17, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээнд 18, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээнд 580, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд 1846 ахмадыг тус тус хамруулаад байна.		Хэрэгжсэн

3.5.6.	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	-	Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна.			Аймгийн Засаг даргын 2025 оны А/586 дугаар захирамжаар Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан. Мэргэжлийн хамтарсан баг ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан сум багийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд чиглэл өгч ажилласан. Ахмад настанд зориулсан 12 төрлийн эрүүл мэндийн мэдээллийг хүргэж 120 гаруй мянган хүнд хүргэж ажилласан байна. Эрүүл мэндийн 4,5-р бүлгийн ахмад настуудын асран халамжлагч нарт холголт цооролтоос урьдчилан сэргийлэх, ахмад настны цогц үнэлгээнд хамруулах, сэтгэл зүйн болон бие махбодийн хүчирхийлэл үйлдэхгүй байх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ахуйн ослоос сэргийлэх зэрэг сэдвүүдийн хүрээнд 5-8 төрлийн асаргаа сувилгааны зөвлөгөө, мэдээллийг хүргэж, гарын авлагаар хангасан байна. Мөн 1,2 дугаар түвшинд үнэлэгдсэн 270 гаруй ахмадыг лавлагаа, мэдээллийн үйлчилгээ, ахмад настны хөгжлийн үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ зэрэгт хамруулаад байна.		Хэрэгжсэн
3.5.7.	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн суралч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо	-	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна.			Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан ахмад настуудад хүндэтгэл үзүүлэх нөлөөллийн арга хэмжээ, алаг мэлхий өрөх, шагай няслах, шагай шүүрэх, морь уралдуулах, мэндлэх хүндлэх ёс,өв уламжлалаа хойч үедээ өвлүүлэх зорилгоор дөрвөн бэрх, асуулт хариултын АХА тэмцээн зэрэг олон талт арга хэмжээнүүдийн зохион байгуулж 8116 ахмадыг хамрууллаа. Арвайхээр сумын ахмадын хороотой хамтран мэдээллийн технологийн чиглэлээр И-монголиа -д нэвтрэх, үйлчилгээ авах, Банкны апплекшин ашиглаж үйлчилгээ авах, тоон гарын үсэг ашиглах зэрэг мэдээллийг өгч ахмадуудын цахим хэрэглээний чадавхийг дээшлүүлэх Хурдан клубыг байгуулж мэдээллийн технологийн гишүүн сургагч багш 18 ахмад настанд батламж олгосон. Ахмад настны ажил, амьдралын мэдлэг туршлага, сургаалыг хүүхэд, залууст үлгэрлэн таниулах, ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэхэд чиглэсэн аян өрнүүлэх 32 арга хэмжээг зохион байгуулж 1210 хүн хамрагдсан байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зохион байгуулах арга хэмжээнд 45 байгууллагын 65 ахмад мэргэжилтэн ажиллуулж хүсэлт ирсэн. Тайлант хугацаанд 22 ахмад настантай гэрээ байгуулан боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, төрийн захиргааны чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулж байна. Аймгийн ахмадын урлаг, спортын наадмыг зохион байгуулж, уртын дуу, үндэсний хөгжим, язгуур урлаг, харилцаа дуу, ерөөл магтаал, бие биелгээ, зохиолын дуу, хошин шог, шүлэг, найрал дуу гэх урлагийн 9 төрөлд 273 уран сайханч оролцож авъяас чадвараараа өрсөлдсөн бол шатар, софт волейбол, ширээний теннис, шагайн харваа, гранд гольф, дартс зэрэг спортын 6 төрөлд 153 тамирчин хурд хүчээ сорьж, нийт 19 сумын 426 ахмадыг хамрууллаа. Мөн багийн болон сумын засаг даргын тамгын газартайгаа хамтран "Ахмадаа сонсоё", "Ахмадын сургааль алт, "Гурван үе" зэрэг уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөгийг зохион		Хэрэгжсэн
3.5.8.	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/	-	Журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.			Аймгийн хэмжээнд харж хандах хүнгүй ганц бие 191 ахмад, амьжиргааны баталгаажих түвшин доогуур орлоготой өрхөд амьдардаг 442 ахмад байна. Эдгээр ахмадууд төрийн үйлчилгээг авахдаа хүндрэлтэй байх, заавал биеэр үйлчилгээ авах зэрэг асуудал гарч байсан тул жил бүр Ач нэхээгүй тус", "Дусал тус", гэх мэт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж байна. Мөн энэ онд Арвайхээр сумын ахмадын хорооноос "Бид очно" арга хэмжээг зохион байгуулж, сумын хэмжээнд харж хандах хүнгүй ганц бие, эмээг бүлгийн 120 гаруй ахмадуудыг хамруулсан. Мөн 80-аас дээш настай ахмад настуудад төрийн анхан шатны үйлчилгээг үзүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан нь гэртээ байдаг, ганц бие, харж хандах хүнгүй ахмад настануудад тустай арга хэмжээ болж хэвшээд байна.	Журам батлагдаагүй	Хэрэгжээгүй

3.5.9.	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын	-	50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо	Суурь түвшний тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.				Хөдөлмөрийн тухай хуулийн 145-р зүйлийн 4 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 50-аас дээш ажилтан, албан хаагчтай аж, ахуй нэгж байгууллагын судалгааг гаргасан ба судалгаагаар 49 байгууллагад 80 ахмад настан ажиллаж байна. 14 байгууллага тус хуулийн хэрэгжилтийг хангаагүй. Хуулийн хэрэгжилт хангаагүй аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.	ААНБ уудын төсөвт тусгагдаагүй бөгөөд 2026 оны төсвийн төсөөлд аж ахуйн нэгж байгууллагууд саналаа хүргүүлж байна.	Хэрэгжсэн
3.5.10.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1. Гухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо	-	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна.				Тус хуулийн 22.9.2.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашигласан аж ахуйн нэгжийн хүсэлт тайлант хугацаанд ирээгүй болно.		
ХЭРЭГЖСЭН ЗААЛТЫН ТОО											60
ХЭРЭГЖЭЭГҮЙ ЗААЛТЫН ТОО											6
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ											90.9

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР